



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/175

Бор-Өндөр сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авч буй "Хөдөлгөөнт эргүүлийн суудлын авто машин худалдан авах" ажлыг шалган, хүлээн авах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Б.Хүрэлбаатар

Бор-Өндөр сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн зохицуулагч /цагдаагийн ахлах дэслэгч/

Нарийн бичгийн дарга

Г.Баасанхүү

Бор-Өндөр сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн нярав /цагдаагийн дэд ахлагч/

Гишүүн:

С.Нармандах

УБҮ-ийн Автотээврийн Засварын механик инженер

2. Хөдөлгөөнт эргүүлийн суудлын авто машиныг шалган, хүлээн авч зохих хууль, журмын дагуу баримт материалыг бүрдүүлэн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Хүрэлбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ